



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТӨРИЙН  
БОЛОН ХУВИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭР,  
КОМПАНИУДЫН УДИРДЛАГУУДАД

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ

Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас/Факс: (976-11) 32 35 79,  
Цахим шуудан: pes@must.edu.mn,  
Цахим хуудас: www.must.edu.mn

2022.09.05 № 01/0362  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сургалт явуулах тухай

Эрчим хүчний сайдын 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 126 тоот тушаалаар батлагдсан зэрэг олгох журмыг үндэслэн "Мэргэшсэн инженер"-ийн зэрэг горилох инженерүүдийн сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Сургалт 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр эхлэх тул байгууллагаасаа журамд заагдсан шаардлагуудыг хангасан, сургалтанд хамруулах саналтай инженерүүдээ бүртгүүлнэ үү. Сургалтын төлбөр: 1,500,000 төгрөг болно.

Бүртгэл 2022 оны 09 дүгээр сарын 05-наас 09 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл <https://surgalt.pes.edu.mn/> гэсэн хаягаар бүртгэнэ. Файл оруулах хэсэгт дараах материалуудыг нэгтгэж, нэг "PDF" файл үүсгэн өөрийн нэрээр /латин үсгээр/ хадгалж оруулсан байх зайлшгүй шаардлагатай. Үүнд:

- Зураг (3x4 хэмжээтэй 1 хувь)
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ажил олгогчийн албан бичиг (суралцуулах шаардлагатай байгаа талаар);
- Ажил байдлын тодорхойлолт (захирлын албан тодорхойлолтоор баталгаажсан);
- Дипломын хуулбар;
- Бүтээлийн жагсаалт

Бүртгэлийн хураамж 10500 төгрөгийг вэб сайт дахь дансаар төлсөн тохиолдолд онлайн бүртгэл баталгаажна.

Жич: "Онлайн системд ажиллах бүртгүүлэх заавар, зөвлөмж"-тэй сайтар танилцсаны дараа маягтуудыг бөглөхийг анхаарна уу. Онлайн системээр хүлээн авсан, шаардлага хангасан материалыг хянан шалгаж, "Салбарын мэргэшлийн зэрэг олгох зөвлөл"-д танилцуулан, суралцах хүмүүсийн сонгон шалгаруулалтыг шийдвэрлүүлнэ.

Холбоо барих утас: 11 325931

ЗАХИРАЛ



Б.БАТ-ЭРДЭНЭ